

## ХИЧЭЭЛ 5

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 9:34-43; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 131, 132.

## Тусламжийн Гар

*Чи хэзээ нэгэн цагт хэн нэгэнд маш сайхан зүйл хийж өгч байсан уу? Чи тэдэнд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ? Чамд ямар санагдсан бэ? Доркас маш олон хүнд сайн зүйлс хийж өгдөг байсан тул Бурхан ч бас түүнийг гайхамшигтай аргаар асарч халамжилсан юм.*

**С**айн байна уу, залуу анд минь. Намайг Табита гэдэг. Энэ бол миний арамей нэр. Харин зарим хүмүүс намайг Доркас гэж дууддаг. Энэ бол миний грек нэр байгаа юм. Та нар намайг аль

ч нэрээр минь дуудаж болно.

Би Есүсийн тухай сонсож итгэгч болсноосоо хойш яг Түүн шиг бусдад тусалдаг байхыг маш их хүсдэг болсон. Хэн нэг нь өвдвөл би очиж уулздаг. Би идэх юм эсвэл дулаан хөнжил аваачиж өгнө. Хэрэв гэр орныг нь цэвэрлэх хэрэгтэй байвал би цэвэрлэж өгнө. Би үргэлж өвчтэй хүнтэй хамт залбирах эсвэл хэрэгтэй бол тэдэнд Есүсийн тухай аз жаргалтай дуу дуулж өгнө.

Ядуу хүмүүст миний тусламж хэрэгтэй. Ялангуяа бэлэвсэн эмэгтэйчүүдэд. Тэдэнд туслах нөхөр нь байхгүй шүү дээ. Би тэдэнд зориулж шинэ хувцас оёж өгөх дуртай.

Би ялангуяа хүүхдүүдэд маш хайртай. Өвдсөн эсвэл аав ээжгүй хөөрхий хүүхдүүдэд би илүү их цаг гаргадаг. Тэдэнд

**Цээжлэх Ишлэл:**

“Харин ядуу хүнд нигүүлсэнгүй хандагч хүн ерөөлтэй”

СУРГААЛТ ҮГС 14:21

**Тол Санаа:**

Бусдад элэгсэг хандахдаа бид өөрсдөө ч бас аз жаргалтай болдог.



хамгийн том аз жаргалаа бэлэглэхийг хүсдэг. Би тэднийг тэвэрнэ. Эсвэл тэдний юу ярихыг нь анхааралтай чагнадаг. Заримдаа би тэдэнтэй хамт тоглодог. Эсвэл би тэдэнд Есүсийн тухай ярьж, шинэ дуу зааж өгнө.

Одоо л би Есүс яагаад үргэлж завгүй хүмүүст тусалж байсныг ойлгож байна. Хэрэв та нар сайн харах юм бол тусламж хэрэгтэй хүмүүс ямар олон байгааг харах болно. Би бусдыг баярлуулах дуртай. Ингэснээр би өөрөө ч бас аз жаргалыг мэдэрдэг юм.

Одоо би та нарт өөртөө тохиолдсон нэгэн гайхамшигтай явдлын тухай ярьж өгье. Гэхдээ эхлэл нь гайхалтай байгаагүй л дээ. Би нэг удаа маш хүнд өвчин туссан юм. Өвчнөөсөө болоод би амьсгал хураасан. Гэхдээ үүнийг надад хүмүүс хэлсэн. Би санадаггүй юм. Гэхдээ л миний найзууд маш их гунигласан гэсэн.

Ашгүй тэр үед бидний анд Петр манай хотод явж байгаад таарсан байна. Хэн нэг нь түүн дээр тэр дороо очоод түүнийг дагуулаад ирж. Найзууд маань уйлаад л сууж байсан гэнэ. Тэд Петрт миний хувцсыг үзүүлээд хүмүүст тусалж байсан үеийн минь тухай ярьж өгчээ. Тэд их сайхан сэтгэлтэй байгаа биз? Тэдний ярихыг сонссон бол би л лав ичих байсан байхаа.

Петр миний төлөө залбирсан гэж дараа нь надад хэлсэн юм. Нэг сэрсэн чинь Петр

миний хажууд сууж байгааг л би харсан. Түүнийг хараад би маш их гайхсан учраас би бүр босох гэж оролдлоо. Петр намайг гараас татаж босгов. Тэгээд бид хоёр олон хүн цуглачихсан байсан нөгөө өрөө рүү явж орсон юм. Гэтэл бүгд гайхшралд орлоо. Дараа тэд баярласандаа хашгиралдсан. Яг юу болсныг нь би одоо болтол сайн ойлгодоггүй юм. Бурхан Петрээр дамжуулан гайхамшиг бүтээж намайг амилуулсан. Надтай тохиолдсон явдлын тухай Иоппа хотод тэр дороо л тархсан. Тэгээд олон хүн Есүст итгэсэн дээ.

Бурхан Петрээр дамжуулан намайг амилуулсанд би маш их баяртай байна. Одоо ч гэсэн би завгүй ажилласаар л байгаа. Олон хүнд миний тусламж хэрэгтэй. Бусдад баяр жаргал өгөх үйлсээ цааш нь үргэлжлүүлэхийг хүсэж байна. Өөрт нь үйлчлэх илүү цагийг гаргаж өгсөнд би Бурханд талархаж байна.



# Дасгал Ажил

## ШАББАТ

Энэ долоо хоногийг өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

**Харин ядуу хүнд**.....Юм гуйж буй мэт гараа сунгах.

**нүүгүүлсэнгүй** .....Нэг гараараа нөгөө гарынхаа алгыг илэх.

**хандагч хүн**.....Нүүр дүүрэн инээмсэглэх. ерөөлтэй.

**Сургаалт үгс 14:21**.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн Аз жаргал дүүрэн аягаа хэн нэг хүнтэй хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. Мөн тэр хүнд Доркасын тухай хүүгээрээ яриулаарай. (цэвэрхэн хуванцар аяган дээр баясгалантай царай зураад дотор нь сайн үйлсийн зураг зурж нугалж хийгээрэй.) Тэд баяр жаргалаар дүүрэн байгаа учраас тэрхүү аз жаргалаа бусадтай хуваалцаж чадна.



## ДАВАА


Үйлс 9:36-43-г хамтдаа уншаарай. Асуух: Доркас яагаад бусдад сайн үйлс хийдэг байсан бэ? Хэн түүнийг амилуулсан бэ? Хэрвээ хүүхэд тань Нийтэд тустай үйлчлэлийн тухай захиа авчирсан бол төлөвлөгөөг нь гаргаж эхлээрэй.

## МЯТМАР

Хүүхэдтэйгээ хамт өнөөдөр бусдыг аз жаргалтай болгох ямар нэг зүйл хийхээр төлөвлөөрэй. Гэрийнхнийгээ баярлуулах арга замыг хүүхэд тань бодож олох болгонд дээш доош нэг нэг үсрээрэй. Дараа нь хамтдаа үсрээрэй. Залбирахын өмнө хамтдаа аз жаргалын тухай дуу дуулаарай.

## ЛХАГВА

Хүүхдүүдээрээ мэддэг багаж, зүйлсийг олуулаарай. Тэдгээрийг ашиглаж хэрхэн бусдад тус болж болох талаар хүүхдэдээ тайлбарлаж өгөөрэй. (алх, шархны лент, хөнжил, утас г.м.) Залбирахаас өмнө тусламжийн дууг дуулаарай.



## ПҮРЭВ

Та өвдсөн болж тоглоорой. Хүүхдээрээ өөрийгөө асруулж, шархны лент хөнжил г.м зүйлсийг авчруулаарай. Дараа нь дүрээ солино уу. Халамжлах тухай дуу дуулаад, дараа нь Бурханаас бусдыг хайрлаж халамжлах арга замыг олоход туслаач гэж гуйна уу.

## БААСАН

Библийн түүхийг гэрийнхэнтэйгээ хамт жүжиглээрэй. Хэн Доркас болох вэ? Хэн Петр болох вэ? Залбирахаасаа өмнө бусдыг халамжлах тухай дуу дуулаарай. Маргааш Шаббат хичээл дээр болох Нийтэд тустай үйлчлэлд зориулж хүүхдэдээ авч явах зүйлийг нь бэлдэж өгнө үү.